

ГХГЗЗГ-ын даргын 2003 оны 157
тоот тушаалын 2-р хавсралт

Улсын бүртгэлийн дугаар _____

**ИРГЭН, ХУУЛИЙН ЭТГЭЭДЭД ГАЗАР
АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ**

2016 оны 05 сарын 16 өдөр

№01/16

Дорноговь аймаг, Дэлгэрэх сум

Нэг, Нийтлэг үндэслэл

Монгол Улсын Газрын тухай хууль, Дорноговь аймаг /нийслэл/-ийн Дэлгэрэх сум /дүүрэг/-ын Засаг даргын 2014 оны 05 сарын 16 -ны өдрийн А/93 тоот шийдвэрийг үндэслэн газар ашиглуулагчийг төлөөлж, Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын Засаг дарга Зүндүй овогтой Батмөнх газар ашиглагчийг төлөөлж, Засаг чандмань майнз ХХК гүйцэтгэх захирал ажилтай Торбат овогтой Эрдэнэбатхаан нар энэхүү гэрээг байгуулав.

Энэхүү гэрээнд гэрээний салшгүй хэсэг болох дараахь зүйлийг заавал тусгах бөгөөд эдгээрийн бүрдэл дутуу бол гэрээг хүчингүйд тооцох үндэслэл болно. Үүнд:

1. Газрын байршил, хэмжээ, хил хязгаар, заагийг тодорхой харуулсан кадастрын зураг
- 1.2. Газар өмчлөгчөөс газар ашиглагчид тус газрыг хүлээлгэн өгсөн тухай акт,
- 1.3. Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг зохих журмын дагуу хийлгүүлж баталгаажуулсан баримт;

Хоёр, Гэрээний нөхцөл

2.1. Газар ашиглагчид олгосон газрын нийт хэмжээ:	_____ 554,53 _____ /га/
Үүнээс:	
Нэгж талбарын тодорхой хэсгийг ашиглах зориулалт	Тухайн зориулалтаар Ашиглах газрын хэмжээ
1. <u>Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа газар</u>	_____ 8,9 _____ /га/
2. <u>Суурьшлын хэсэг</u>	_____ 6,7 _____ /га/
3. <u>Бусад</u>	_____ 538,93 _____ /га/
4. _____	_____ /га/

2.2. Газрын төлбөрийн хэмжээ:

Уурхайн эдэлбэрийн ашиглалт явуулж байгаа газар
 Нэгжийн үнэ 1га-160000 төгрөг /үсгээр/ Нэг зуун жаран мянган төгрөг
 Бүгд үнэ 1424000 төгрөг /үсгээр/ Нэг сая дөрвөн зуун хорин дөрвөн мянган төгрөг
 Үүнээс:
 1-р улиралд 356000 төг 3-р улиралд 356000 төг
 2-р улиралд 356000 төг 4-р улиралд 356000 төг

Газар эзэмшүүгчийн тогтоолж гарын үсэг

Газар эзэмшүүгчийн тогтоолж гарын үсэг

ЭХ СУРВАЛЖ: WWW.TODGEREE.MN

Суурьшлын хэсэг

Нэгжийн үнэ 1га-2400 төгрөг /үсгээр/ Хоёр мянга дөрвөн зуун төгрөг

Бүгд үнэ 16080 төгрөг /үсгээр/ Арван зургаан мянга наян төгрөг

Үүнээс:
 1-р улиралд 16080 төг 3-р улиралд _____ төг
 2-р улиралд _____ төг 4-р улиралд _____ төг

Бусад

Нэгжийн үнэ 1га-92 төгрөг /үсгээр/ Ерэн хоёр төгрөг

Бүгд үнэ 49582 төгрөг /үсгээр/ Дөчин есөн мянга таван зуун наян хоёр төгрөг

Үүнээс:
 1-р улиралд 49582 төг 3-р улиралд _____ төг
 2-р улиралд _____ төг 4-р улиралд _____ төг

2.3. Газрын төлбөрийг улирал бүрийн эхний сарын 25-ны дотор газар ашиглуулагчийн Дорноговь аймгийн төрийн сан банкин дахь 060000943 тоот дансанд шилжүүлж байна.

2.4. Газар ашиглуулах тухай эрх бүхий Засаг даргын шийдвэр гарсан өдрөөр газрын төлбөр хийх хугацааг тогтооно.

2.5. Эрх бүхий байгууллагын шийдвэрээр газрын төлбөрийн хэмжээ өөрчлөгдөх тохиолдолд гэрээнд өөрчлөлт оруулна. Ийнхүү газрын төлбөрийг шинэчлэн тогтоолгоогүй бол зохих зардлыг газар ашиглагч хүлээнэ.

Гурав, Газар ашиглагчийн эрх, үүрэг

- 3.1. гэрээний нөхцлийн дагуу газрыг ашиглах;
- 3.2. газар өмчлөгчөөс газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг гаргуулж авах;
- 3.3. гэрээнд үүргээ зохих ёсоор биелүүлж ирсэн бол эрхийн гэрчилгээний хугацаа дуусахад уг газрыг үргэлжлүүлэн ашиглахаар эрхийн гэрчилгээний хугацааг сунгуулах;
- 3.4. газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгааг тогтоосон журмын дагуу хийлгэж байх 15 жилд нэг удаа хийлгэнэ;
- 3.5. газрын төлбөрийг газрын ашигт шинж чанарыг ашигласан эсэхээс үл хамааран хугацаанд нь төлөх;
- 3.6. төлбөр төлөх үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй тохиолдолд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувиар хэтэрсэн хоног тутамд алданги төлөх;
- 3.7. газар өмчлөгчөөс газрын ашиглалттай холбогдуулан тавьсан шаардлагыг цаг тухайд нь биелүүлэх;
- 3.8. Шалгарсан төслийг хэрэгжүүлж ажиллах
- 3.8. холбогдох хууль тогтоомжоор тогтоосон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх;

Дөрөв, Газар ашиглуулагчийн эрх, үүрэг

- 4.1. газрыг гэрээнд заасан зориулалтын дагуу ашиглаж байгаа эсэхийг хянах;
 - 4.2. уг газрыг ашиглуулахын зэрэгтээ дараахь шаардлагыг газар ашиглагчид тавих эрхтэй.
- Үүнд:

Газар эзэмшүүгчийн тогтоолж гарын үсэг

Газар эзэмшүүгчийн тогтоолж гарын үсэг

- Газрыг үр ашигтай зохистой ашиглах, хамгаалах, байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомж болон төрийн эрх бүхий байгууллагаас газар ашиглалттай холбогдуулан тавьсан нийтлэг шаардлагыг биелүүлэх, байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнээс гарсан зөвлөмжийг мөрдөж ажиллах

- Ашиглалтын явцад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлсэн бол ашиглагч өөрийн хөрөнгөөр уг элэгдэл, эдвэрд орсон газрыг сэргээн сайжруулах

- Орчны бохирдлоос сэргийлэх арга хэмжээг газар ашиглагч өөрийн хөрөнгөөр авч хэрэгжүүлнэ.

- Газрын тухай хууль тогтоомж, газар ашиглах гэрээний нөхцөл, болзлыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн

- Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр гэрээнд заасан зориулалтын дагуу тухайн газраа 2 жил дараалан ашиглаагүй тохиолдолд газар ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгоно.

4.3. Газрын тухай хуулийн 35.3.1.-35.3.6.-д заасан үүргээ гүйцэтгээгүй, энэ талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд гэрээг цуцалж, мөн хуулийн 62 дугаар зүйлд зааснаар хохирлыг нөхөн төлөхийг шаардах.

4.4. газар ашиглуулах гэрээг жил бүр дүгнэх.

4.5. холбогдох хууль тогтоомжоор олгогдсон бусад эрх, үүрэг, хариуцлага хүлээх.

Тав. Газрын талаарх эд хөрөнгийн эрхийн зарим зохицуулалт

5.1. газар ашиглагчийн өмчлөлд байгаа тухайн газар дээрх үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөх эрх өөр этгээдэд шилжвэл **2 тал харилцан тохиролцсоны үндсэн дээр газар ашиглах эрхийг шилжүүлж болно** гэж шийдвэрлэнэ.

5.2. энэхүү гэрээгээр ашиглах газрыг хязгаартай ашиглах эрх бүхий газар ашиглагч байгаа болон ийнхүү ашиглахаар шаардсан бол түүний газар ашиглах нөхцөл, журам нь газрын тухай хуулийн 48-р зүйлд заасан нөхцөлийг дагаж мөрдөх болно. Шаардлагагүй гэж үзвэл энэхүү гэрээнд хавсаргаж болно.

5.3. гэрээний талуудын шаардлагатай гэж үзсэн бусад нөхцөл: Ашиглах эрх бүхий газраа зориулалтын дагуу ашиглаагүй болон тогтоосон төлбөрийг зохих журмын дагуу төлөөгүй тохиолдолд газар ашиглах эрхийг нь хүчингүй болгох хүртэл арга хэмжээ авч газар дээрх эд хөрөнгийн эрхийн асуудлыг шүүхийн журмаар шийдвэрлэнэ. Мөн Зохих зөвшөөрөлгүйгээр газрын хэмжээнд өөрчлөлт оруулсан нөхцөлд газар ашиглах эрхийг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Зургаа. Бусад зүйл

6.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

6.2. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Долоо. Бусад зүйл

7.1. Гэрээ нь газар ашиглагчид газрыг актаар хүлээлгэн өгч, эрх бүхий Засаг дарга газар ашиглах эрхийн гэрчилгээ олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

Газар эзэмшүүгчийн төлөөлж гарын үсэг

Газар эзэмшээчийн төлөөлж гарын үсэг

ЭХ СУРВАЛЖ: WWW.IKODGEREE.MN

7.2. Энэхүү гэрээг гурван хувь үйлдэж талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн **Хоёр** /үсгээр/ жилийн хугацаатай байгуулав.

7.3. Газар ашиглуулах гэрээг талууд жил бүр дүгнэх ба газар ашиглагч гэрээний биелэлтийг жилийн бүрийн 04-р сарын 01-ны дотор багтаан тайлагнаж, газар ашиглуулагч 04-р сарын 15-ны дотор багтаан дүгнэнэ.

7.4. Газар ашиглуулах гэрээг дүгнүүлээгүй, өмнөх гэрээний биелэлт тоолсон дүгнэлтээр илэрсэн зөрчлүүдийг арилгах арга хэмжээ аваагүй, дахин давтагдсан тохиолдолд Газрын тухай хууль тогтоомжийн дагуу газар ашиглах эрхийн гэрчилгээг хүчингүй болгох саналыг холбогдох албан тушаалтанд уламжлан шийдвэрлүүлнэ.

7.5. Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

Гэрээний талуудын албан ёсны хаяг, харилцах утас:

Газар ашиглуулагч Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын ЗДТГазар
Дорноговь аймаг, Дэлгэрэх сум, 1-р баг
Утас: 70526404

Засаг чандмань майнз

ХҮК

Газар ашиглагч Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Баруун сэлбэ гудамж,
17-р хороо

Регистр / улсын бүртгэл /-ийн дугаар

5	3	8	2	4	3	2		
---	---	---	---	---	---	---	--	--

Харилцах дансны дугаар: Голomt банк 8145100155

Харилцах утас: 70114888

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Газар ашиглуулагчийг төлөөлж:

Дорноговь аймаг /нийслэл/-ын
Дэлгэрэх сумын Засаг дарга
Зундуй овогтой Батмөнх

гарын үсэг/ Зундуй /тамга/

Газар ашиглагчийг төлөөлж:

Засаг чандмань майнз ХХК-ний гүйцэтгэх
захирал
Төрбат овогтой Эрдэнэбатхаан

ZASAGCHANDMANI MINES LLC
/гарын үсэг/ Төрбат /тамга/
TTC №3538

Энэхүү гэрээний нэг хувийг 4404003001 дугаар бүхий нэгж талбарын хувийн хэргийг хадгалав

Газар эзэмшүүгчийн төлөөлж гарын үсэг

Газар эзэмшээчийн төлөөлж гарын үсэг